



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 дугаар
сарын 20-ний өдөр

№ 1

Улаанбаатар хот

**КОМПАНИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН ХЭЛЭЛЦЭХ ТУХАЙ**

“Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн дүрмийн 7.7.2, 7.58.13-ыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Компанийн гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-ын тавьж хэлэлцүүлсэн “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж ажлын үр дүнг “Бүрэн хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Тайланг ХЭХ-д тавьж хэлэлцүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 дугаар
сарын 20-ны өдөр

№ 2

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх хяналт тавих” журам, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн дүрмийн 7.3 дах заалт тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн 14:00 цагт хуралдуулахаар тогтсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Хан-Уул дүүрэг 15-р хороо, ЭЛ-ЭС плазагийн 11 давхар, 1102 тоотод зохион байгуулж холбогдох зардлыг гүйцэтгэх захирал (Д.Санжаа) хариуцан ажилласугай.
3. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг танхимаар болон цахим хэлбэрээр зайнаас оролцох боломжийг хувьцаа эзэмшигчдэд олгож ажиллахыг гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д даалгасугай.
4. Тус хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай.
 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэх тухай.
 2. Ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах тухай.
 3. Нэмэлт хувьцаа гаргах тухай.
 4. ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, сонгох тухай.

5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 4 дүгээр сарын 10 – ны өдрөөр тасалбар болгон тогтоосугай.
6. Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК-ний хувьцаа эзэмшигчийн анхааралд хавсралт №1, ээлжит хурлыг дэгийг хавсралт №2, хуралд оролцох хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийг хавсралт №3, ээлжит хуралд санал авах хуудсыг хавсралт №4-өөр тус тус баталсугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 4 дугаар сарын 29 –ний өдөр зарлан хуралдуулахыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ж.Жаргалсайхан)-д үүрэг болгосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаарх санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 4 дүгээр сарын 29-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
9. Хурлын үед ажиллах тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.
 1. З.Төрболд (дарга)
 2. Ш.Нарангаравуу(гишүүн)
 3. Х.Ариунжаргал (гишүүн)Ээлжит хурлын санал авах үйл явцтай холбогдол бүхий баримт бичгүүдийг боловсруулах, баталгаажуулах, санал авах үйл явцыг зохих журмын зохион байгуулахыг тооллогын комисс (З.Төрболд)-д даалгасугай.
10. Ээлжит хурлыг зохион байгуулах комиссын даргаар гүйцэтгэх захирал (Д.Санжаа), ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Э.Нямгарам), ерөнхий нягтлан бодогч (Т.Ганчимэг) нарыг тус тус томилсугай.
11. Хурлаар хэлэлцүүлэх баримт, бичгүүдийг нэг бүрчлэн нягталж зар хүргэх сувгуудад байршуулах ажлыг зохион байгуулах хороонд үүрэг болгосугай.
12. Ээлжит хурлыг зайнаас цахим хэлбэрээр зохион байгуулах, удирдах, асуулт хариултыг зохион байгуулахыг гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д даалгасугай.
13. Хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг гаргахыг ерөнхий нягтлан (Т.Ганчимэг)-д зөвшөөрсүгэй.

14. Ээлжит хурлын зарыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, радио телевизээр 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр, давтамж зарыг 4 дүгээр сарын 8-ний өдөр багтаан мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерын компанид хүргэж хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, танилцуулга бэлдэх, хурлаас гарах шийдвэр бусад холбогдох бичиг баримтуудыг боловсруулах, зар хүргэх асуудлуудыг тус тус зохион байгуулахыг комиссын дарга, Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 дугаар
сарын 20-ний өдөр

№ 3

Улаанбаатар хот

НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ

Монгол Улсын компанийн тухай хуулийн 46.2 дах заалт, ТУЗ-ын гишүүдийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн 2022 оны ногдол ашгийг хуваарилахгүй байхаар тогтсугай.
2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар гаргасан шийдвэрийг хувьцаа эзэмшигч нарт мэдээлэхийг гүйцэтгэх захирал /Д.Санжаа/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 дугаар
сарын 20-ны өдөр

№ 4

Улаанбаатар хот

ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙГ ЧӨЛӨӨЛӨХ, НӨХӨН СОНГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, 77.5, Компанийн дүрмийн 7.27 үндэслэн **ТОГТООХ нь:**

1. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 5.1 заалтыг үндэслэн, мөн өөрийн саналаар гарах хүсэлтэй байгаа гишүүдийг чөлөөлж, нөхөн сонгууль явуулахыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэсүгэй.
2. ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөх, нөхөн сонгох сонгуулийг зохион байгуулах үйл ажиллагааг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зохион байгуулах комиссын дарга (Д.Санжаа), нэр дэвшүүлэх хорооны дарга (Д.Орхон) нарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 3 дугаар
сарын 20-ны өдөр

№ 5

Улаанбаатар хот

ХӨТӨЛБӨРИЙГ ТУСГААРЛАХТАЙ ХОЛБООТОЙ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл, 83 дугаар зүйл, Хувьцаа эзэмшигчдийн 2021.1.31-ний ээлжит бус хурлын тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Тусгаарлах замаар байгуулагдсан охин компани руу, Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлж, бүртгэл тайлагналыг НХҮН ХК-ийн санхүү нягтлан бодох бүртгэлд тусгайлан бүртгэж, тусгаарлагдсан компанид актаар хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа) Нягтлан бодогч (Т.Ганчимэг), хөтөлбөрийн үйл ажиллагаа хариуцсан менежерүүдэд үүрэг болгосугай.
2. Шинээр байгуулагдсан охин компанийн гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, менежерүүд нь 2022 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс ажил хүлээлцэх өдрийг хүртэлх хөтөлбөрийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэл, тайланг ажил хүлээлцэх актаар шилжүүлэн авч, тасралтгүй үргэлжлүүлэх үүрэг хүлээх учрыг дурдсугай.
3. Хөтөлбөрийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр охин компанид шилжүүлж байгаатай холбогдуулан НХҮН ХК-аас 2022 он болон 2023 оны эхний саруудад /тусгаарлах үйл ажиллагааг дуусгавар болгох буюу 2023 оны 05 дугаар сарын 30 хүртэл хугацаанд/ харилцагч байгууллагууд болон хөтөлбөрт оролцогч ТББ, иргэдтэй хийсэн ирээдүйд хэрэгжих гэрээ хэлцэл, урьдчилсан тохиролцоо, санамж бичиг, гэрээ хэлцлийг охин компанид шилжүүлэхдээ тэдгээр гэрээ, хэлцэл, урьдчилсан тохиролцоо, хэлэлцээрийн шатанд байгаа ажлуудыг бүрэн гүйцээн хэрэгжүүлэх. *Тухайлбал: а/ Орон сууцыг давуу эрхийн хувьцаагаар худалдан авах талаар барилгын компаниудтай хийсэн урьдчилсан тохиролцоо гэрээ хэлцлийг зохих ёсоор албажуулах, шаардлагатай бол байгуулсан гэрээ хэлцэлд нэмэлт,*

өөрчлөлт оруулах. б/ НХҮН-ээс хувьцаат орон сууц хөтөлбөрт зориулан гаргахаар төлөвлөж байсан хаалттай давуу эрхийн хувьцааг охин компани өөрийн нэр дээр гаргахаар тооцож, хөтөлбөрт хамрагдагч болон стратегийн түншлэлийн төслийн орон сууц ханган нийлүүлэгчдийг хаалттай хүрээнд хувьцаажуулах.

в/Хувьцаат орон сууц хөтөлбөрийн хүрээнд өмнө хийгдсэн гэрээ хэлцлүүдийг тусгаарлагдсан охин компани өөрийн нэр дээр шинэчлэн байгуулах гэх мэт/-чиглэлээр үйл ажиллагааг зохион байгуулахыг НХҮН ХК-ийн болон тусгаарлах замаар өөрчлөн байгуулагдах охин компанийн ХЭХ, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагад үүрэг чиглэл болгосугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн Аудитын хороо (Отгонцэцэг)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН